



ТӨВ АЙМГИЙН
СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/744

Эрдэнэ-Уул

ЗЭЭЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 81 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 47 дугаар тогтоол, Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх төсөл сонгон шалгаруулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн төсөл сонгон шалгаруулах хурлаар төсөл нь дэмжигдсэн хавсралтад нэр заагдсан 10 төсөлд 145,500,000 (нэг зуун дөчин таван сая таван зуун мянга) төгрөгийг олгосугай.

2.Төсөл хэрэгжүүлэгчидтэй зээлийн гэрээ байгуулж, зээлийн зориулалт, гэрээний биелэлт, хэрэгжилтийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж ажиллахыг төсөл сонгон шалгаруулалтын хорооны дарга (Л.Дашлхагва), хорооны нарийн бичиг (Г.Энхтамир) нарт үүрэг болгосугай.

3.Дээрх зардлыг Хоршоо хөгжүүлэх сангаас олгохыг сангийн сумын Ерөнхий нягтлан бодогч (П.Гантуяа)-д зөвшөөрсүгэй.

4.Гэрээний үүргээ биелүүлж, зориулалтын дагуу зарцуулан гэрээнд заасан үүргээ хугацаанд нь биелүүлэх, гэрээний үүргээ биелүүлээгүй, графикт хугацаанд эргэн төлөлт хийгээгүй, зээлийг зориулалт бусаар ашигласан тохиолдолд зээлийн гэрээнд заасны дагуу зээлийг буцаан татах, хүү алдангийг нэмэгдүүлэн тооцож, шүүхээр шийдвэрлүүлэх болохыг анхааруулсугай.

5.Зээлийн зарцуулалтад хяналт тавьж, мэдээ тайланг цаг хугацаанд нь гаргаж байхыг Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн (Г.Энхтамир), Санхүү албаны дарга (П.Гантуяа), хяналтын зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Л.ТӨМӨРЧӨДӨР

My doc zahiramj 2023 on

Сумын Засаг даргын 2023 оны
06 сарын 22-ны өдрийн
А/24 тоот захирамжийн хавсралт

№	Төслийн нэр	Төсөл хэрэгжүүлэгч	Төслийн танилцуулга	Сум хөгжлүүлэх сангаас хүссэн хэмжээ	Олгосон
01	Гоё хашаа	Ч.Ичинхорлоо	Евро бетон хашаа	27,130,000	15,000,000
02	Тоглоомын төв байгуулах	Х.Нандингэрэл Ө.Бат-Ирээдүй	Сумын төвд биллиард, ширээний теннис ажиллуулах	20,000,000	20,000,000
03	Эрдэнэ-Уулын Өгөөж	М.Оргил	Ногоон тэжээл тариалах	40,000,000	20,000,000
04	Цайны газар байгуулах	Ч.Энх-Аръяа Б.Алтанцаг	Цайны газар ажиллуулах	40,000,000	20,000,000
05	Нөхөрлөлийн хоршоо	Ж.Лхамсүрэн	Сумын иргэд, малчдыг шинэ ногоогоор хангах	50,000,000	5,500,000
06	Цагаан толгойт	Э.Дуламсүрэн	Тугал, бяруу бордох	40,000,000	10,000,000
07	Төрөлжсөн мал эмнэлэг	Гурван хангай ХХК	Сумын төвд төрөлжсөн мал эмнэлэг байгуулах	50,000,000	20,000,000
08	Сайхан оёдол	Л.Энхтуул	Орчин үеийн европ, үндэсний хувцас үйлдвэрлэл, засвар үйлчилгээ	30,000,000	15,000,000
09		Ч.Даваадорж	Мах сүүний хосломол өндөр ашиг шимт үхрийн үржүүлэг	20,000,000	15,000,000
10		Л.Тунгалаг	Ургац	5,000,000	5,000,000